



ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
ДАРГА О.ЧУЛУУН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mmhi.gov.mn>

2022.05.13 № 03/1402
танай -ны № -т

Г Акт, албан шаардлага,
зөвлөмж хүргүүлэх тухай

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийж, аудитын хүрээнд Геологийн судалгааны ажлын санхүүжилт, Үндэсний геологийн албаны санхүүгийн тайланг тус тус түүвэрлэн аудит хийж гүйцэтгэсэн байна.

Аудитын хүрээнд түүврээр илэрсэн алдаа, зөрчилтэй холбогдуулан Аудитын байгууллагаас гаргасан акт, албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар үүгээр хүргүүлж байна.

Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хуулийн хугацаанд биелэлтийг ханган ажиллаж, акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний яаралтай эргэн мэдэгдэнэ үү.

Хавсралт хуудастай.



ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Ундэсний геологийн алба /агентлаг/

Тайлант хугацаа: 2021.12.31

Аудитын код: Түүвэр

№	Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утта	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдаж байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагдаж байгууллагын холбогдох хүний	
								Албан тушаал	Овог нэр
A	1	3	4	5	6	7	8	9	10
	Мөнгөн хөрөнгө	Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ бүртгэлд тусгасан	4,500.0	Зөвлөмж			Ж.Борис	Үндэсний геологийн албаны дарга, Ахлах нягтлан бодогч	О.Чулуун Э.Мягмарсайхан
	Төсөв гүйцэтгэл	Батлагдсан эдийн засгийн ангиллыг мөрдөөгүй, зохих журмын дагуу төсөвт зохицуулалт хийгээгүй нийт 15,128.5 мянган төгрөгийг бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй.	15,128.5	Зөвлөмж			Ж.Борис	Үндэсний геологийн албаны дарга, Ахлах нягтлан бодогч	О.Чулуун Э.Мягмарсайхан
	Зардал	Газрын даргад дээд шатны төсөв захирагчийн шийдвэргүйгээр үр дүнгийн болон эзлжийн амралтадаа биеэр эдэлж чадаагүй үеийн мөнгөн урамшуулалт бодож олгосон.	3,155.1	Төлбөрийн акт			А.Дж	Үндэсний геологийн албаны дарга, Ахлах нягтлан бодогч	О.Чулуун Э.Мягмарсайхан
	Зардал	Тайлант онд нийт 43,021.7 мянган төгрөгийн урамшуулалт бодож олгосон.	43,021.7	Зөвлөмж	Нийцэжүүлж асаж, алж жагсаан төрж шалтгаалж бодож А.Ш.Очир		А.Дж Шалтгаалж бодож А.Ш.Очир	Үндэсний геологийн албаны дарга, Ахлах нягтлан бодогч	О.Чулуун Э.Мягмарсайхан
	Биет бус хөрөнгө	Биет бус хөрөнгө буюу нийт 62,131.9 сая төгрөгийн геологийн судалгааны ажлын тайлангуудыг бөөн дүнгээр, 2 ширхэгээр нягтлан бодож бүртгэлд тусгасан байна.		Зөвлөмж			Ж.Борис	Үндэсний геологийн албаны дарга, Ахлах нягтлан бодогч	О.Чулуун Э.Мягмарсайхан
	Орлого	Архивын лавлагааны болон мэдээлэл технологийн үйлчилгээний орлого бүрдүүлэлтэй холбоотой анхан шатны баримт бүрдүүлж, архивын нэгж үүсгээгүй, холбогдох мэргэжилтнүүдээр тайлан гаргуйж, тооцоо хийж хөвшээгүй байна. Мөн ТЕ3-ийн төлөвлөгөөнд тус орлогыг АМГТГ бүрдүүлэхээр баталж байна.		Зөвлөмж	Геологийн баримтын төв архив болон Геом- мэдээллийн төвөөс иргэд ААН- д үзүүлж буй үйлчилгээ нь УГА- ны хуулиар зохицуулсан үндсэн чиг үүрэгт хамаарах ажил боловч үйлчилгээний орлогын төлөвлөгөө нь АМГТГ-ын төлөвлөгөө, гүйцэтгэлд тооцогдож байгааг УГА-ны төлөвлөгөөнд салгаж тусгаж өнө үү		Ж.Борис	Үндэсний геологийн албаны дарга, Ахлах нягтлан бодогч	О.Чулуун Э.Мягмарсайхан

	Авлагын тайллан гаргахын ёмне харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж хэвшээгүй.		Зөвлөмж			<i>С. Ч. Ч. Ч. Ч.</i>	Үндэсний геологийн албаны дарга, Ахлах нягтлан бодог	О.Чулуун Э.Мягмарсайхан
Нягтлан бодох бүртгэл	Урьдчилж төлсөн төлбөр буюу даатгал, програм хангамжийн лицензийн төлбөр зэрэг ажил үйлчилгээний төлбөрийн хэрэгжих хугацаа дусаагүй байхад тайлант үеийн зардлаар бүртгэсэн.	45,530.8	Запруулга хийх			<i>С. Ч. Ч. Ч. Ч.</i>	Үндэсний геологийн албаны дарга, Ахлах нягтлан бодог	О.Чулуун Э.Мягмарсайхан
Хууль нийцэл	Ур чадварын нэмэгдэл олгох шалгур үзүүлэлт батлаагүй, ямар нэгэн үнэлгээгүйгээр сар бүр тогтолц 10-25 хувиар тооцож олгосон.		Албан шаардлага	ҮГА-ыг үүсгэн байгуулахдаа АМГТГ-ын үндсэн бүтэц орон тооноос шилжүүлэх замаар тэнд ажиллаж байсан ТЗ, ТҮ-ний албан хаагчдыг шилжүүлэн ажиллуулсан. Терийн албаны тухай хуулийн 44.3 дэх хэсэгт Энэ хуулийн 44.1, 44.2-т заасны дагуу терийн жинжнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулахдаа эрхэлж байгаа албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хэлс, зэрэг дэвийг бууруулахгүй гэж заасны үндэспэл болгосон.		<i>А. Ч. Ч. Ч. Ч.</i> <i>Ш. Ч. Ч. Ч. Ч.</i>	Үндэсний геологийн албаны дарга, Ахлах нягтлан бодог	О.Чулуун Э.Мягмарсайхан
Нийт дүн		111,336.1						

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

Хянасан:

Аудитын менежер

Аудитын хоёрдугаар газрын захирал,

Тэргүүлэх аудитор

Б.Эрдэнэзүл Огноо:

Танилцаж зөвшөөрсэн:

Үндэсний геологийн албаны дарга

О.Чулуун

Д.Энхдалай Огноо:

Нягтлан бодогч

Э.Мягмарсайхан

Ц.Наранчимэг Огноо:



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 04 дугаар сарын 25

№ 163/2016 0063

Улаанбаатар хот

АХГ- 2022/218/ЧА-СТА-ПЧЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний Геологийн албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илрэлзээ. Үүнд:

Газрын даргад дээд шатны төсөв захирагчийн шийдвэрлгүйгээр үр дүнгийн болон ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй үеийн мөнгөн урамшуулалд нийт 3,155.070.8 төгрөгийг тооцож олгосон.

Энэ нь Засгийн Газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.3 "агентлагийн төсвийн ерөнхий менежерийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулах, биелэлтийг хангах", Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 "Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэлж дүгнэнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бурдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Үндэслэлгүй олгосон цалингийн нэмэгдэл 3,155.070.80 /гурван сая нэг зуун тавин таван мянга далан төгрөг наян мөнгө/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкан дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Үндэсний Геологийн албаны дарга О.Чулуун, нягтлан бодогч Э.Мягмарсайхан нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХӨЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

З.Ж.
Д.О.
Х.

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

АХЛАХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭЗУЛ

1006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тооруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

110.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0425 Auditin 1 Gazar-4.Docx

0001090390



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 25 № 873/АО160063
Ахг 2022/219/ЧВ-СТ-ПЧЗ
Г Зөрчил арилгах тухай Г

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний геологийн албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангагүй, нийт албан хаагчдад 43,021,676.0 төгрөгийн урамшуулал бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 "... шагнал, урамшуулал олгохгүй байх, ..." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлэсгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын Төсвийн хэмнэлтийн талаар гаргасан тогтоол, холбогдох дээд шатны төрийн байгууллагуудаас гаргасан тушаал, шийдвэрийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх, алан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний Геологийн албаны дарга О.Чулуун, няглан бодогч Э.Мягмарсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:	
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	ЦНАРАНЧИМЭГ Д.ЭНХДАЛАЙ Б.ЭРДЭНЭЗУЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР	
АХЛАХ АУДИТОР	
 9006109 9019120396	

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardлага\2022\0425 Auditin 2 Gazar-92.Docx

0001082219



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 25 № 872/А0160063
Ахр- 2020/018/НЛ-СТЭ-ТЧ3
Г Зөрчил арилгах тухай Г

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний геологийн албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт батлаагүй, сар бүр тогтмол 10-25 хувиар тооцож цалин олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан журмын 4 "Энэ журмыг үндэслэн тухайн салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтооно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлэсгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Ур чадварын нэмэгдлийн шалгуур үзүүлэлтийг батлуулан мөрдөж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний Геологийн албаны дарга О.Чулуун, нягтлан бодогч Э.Мягмарсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:	
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР АУДИТЫН МЕНЕЖЕР АХЛАХ АУДИТОР	ЦНАРАНЧИМЭГ Д ЭНХДАЛАЙ Б.ЭРДЭНЭЗУЛ
9006109 9019120396	

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardлага\2022\0425 Auditin 2 Gazar-91.Docx

0001082217



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 04 дугаар сарын 25 № 823/00/70085
дхг-2020/016/иа-стя-пчз

Улаанбаатар хот

Г Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Геологийн байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Геологийн судалгааны ажил гүйцэтгэхээр 2012-2014 онуудад гэрээ байгуулсан 2 байгууллагын 943,792,869.00 төгрөгийн ажлын гүйцэтгэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр дүгнүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14 дүгээр зүйлийн 14.2.5 "Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн чил ажиллагааг хангах", Уул уурхайн сайдын 2015 оны 108 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 2.7 "Төсөл гүйцэтгэгч нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны улмаас төсөл хэрэгжүүлэх хугацаа хойшлох болон төслийн ажлын арга аргачлалд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх зэрэг асуудлыг төрийн захирагааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ", 3.22 "Төсөл гүйцэтгэгч ир... геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланг хугацаандaa Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл, Геологийн мэдээллийн төв архивт хүлээлгэн өгөөгүй тохиолдолд төрийн захирагааны төв байгууллага санхүүжилтийг нь зогсоох, .. 5 дугаар зүйлийн 5.1 "Төсөл гүйцэтгэгч нь геологийн судалгааны ажлын үр дүнд шүүмж хийлгэн, Монголын стратиграфийн комисс, болон Редакцийн зөвлөлийн дүгнэлт гаргуулж, холбогдох мэргэжилтнүүдээр хянуулан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж хамгаална" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дүтээр зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны A/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

- Ажлын гүйцэтгэл буюу ажилтгүйцэтгэсэн гэрээг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлээгүй зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХӨӨРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.ЛХАГВАСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

W0.10.10.20\Bichig_Kirdeg\Alban_Shaardлага\2022\0425_Auditin_2_Gazar-28.Docx

9006109
9019120396

0001082082



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 04 дугаар сарын 25 № 820/20150053
АХГ-2022/016/ЧА-СТА-ПЧЗ

Улаанбаатар хот

Г Зөрчил арилгах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Геологийн байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Геологи судалгааны ажил гүйцэтгэхээр 2017-2018 онуудад гэрээ байгуулсан 8 байгууллагын 6,972,196,352.00 төгрөгийн ажлын гэрээ гүйцэтгэх болон дүгнэх хугацаа 2 хүртэх жилээр хойшилсон бөгөөд, зарим ажлын гэрээний хугацаанд өөрчлөлт оруулаагүй, байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14 дүгээр зүйлийн 14.2.5 "Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", Уул уурхайн сайдын 2015 оны 108 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх үр дүнг тооцох журам"-ын 2.7 "Төсөл гүйцэтгэгч нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны улмаас төсөл хэрэгжүүлэх хугацаа хойшлох болон төслийн ажлын арга аргачлалд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх зэрэг асуудлыг төрийн захирагааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ", 3.22 "Төсөл гүйцэтгэгч нь... геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланг хугацаандаа Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл, Геологийн мэдээллийн төв архивт хүлээлгэн өгөөгүй тохиолдолд төрийн захирагааны төв байгууллага санхүүжилтийг нь зогсох, .. 5 дугаар зүйлийн 5.1 "Төсөл гүйцэтгэгч нь геологийн судалгааны ажлын үр дүнд шүүмж хийлгэн, Монголын стратиграфийн комисс, болон Редакцийн зөвлөлийн дүгнэлт гаргуулж, холбогдох мэргэжилтнүүдээр хянуулан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж хамгаална" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захирагааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийн таслан зогсох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны A/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

- Гэрээний хугацаа хэтэрсэн дээрх 8 ажлыг Эрдэс баялгийн мэргэжлийн дүгнэлт гаргуулан, дуусгавар болгох, цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах арга хэмжээг авч, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, ерөнхий нягтлан бодогч М.Нямсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.ЛХАГВАСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264 230

W10.10.10.20Bichig_KhuregAlban Shaardлага/2022/0425 Auditin_2 Gazar-29.Docx

9006109
9019120396

0001032084